



МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

ДУГААР 13



ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

3,4 CAP

2024.05.05 - Дугаар/13/



СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ 2024 ОНЫ ЭХНИЙ ХУРАЛДААН БОЛЛОО

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Сургалтын хөтөлбөрийн орон тооны бус хорооны ээлжит хуралдаан 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр болж өнгөрлөө.


Хуралдаанаар шүүгчийн сургалтын заавал судлах болон сонгон судлах дараах 16 хөтөлбөрийг хэлэлцэн, гишүүдийн олонх дэмжсэн тул Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т заасан зохицуулалтын дагуу Ерөнхий зөвлөлтэй зөвшилцөн, Ерөнхий шүүгчид хүргүүлэхээр тогтлоо.

БРЮССЕЛЬ, ГААГ, ЛЮКСЕМБУРГ ХОТУУДАД АЖЛЫН АЙЛЧЛАЛ ХИЙВ

Ханнс-Зайделийн сангийн эрх зүйн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаач З.Янжинлхам болон Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Хүний эрхийн комиссын гишүүн Б.Энхболд, нар 2024 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 03 дугаар сарын 23-ны өдрийн хооронд Брюссель, Гааг, Люксембург хотноо зочилж Олон Улсын Эрүүгийн шүүх, Олон Улсын шүүх болон Европын холбооны бусад байгууллагуудаар айлчлал хийж, туршлага судаллаа.



МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ СЭТГҮҮЛИЙН ШИНЭ ДУГААР ХЭВЛЭГДЛЭЭ



“Монголын төр, эрх зүй” сэтгүүлийн 107 дах буюу 2024 оны 1-р улирлын шинэ дугаар хэвлэгдэн гарлаа.

Энэ улирлын дугаарт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхэд анхаарах зарим асуудал; Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй дэх бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Япон улстай харьцуулах нь; Улс төрийн намын бүртгэл хөтлөх талаарх Монгол Улсын зохицуулалтын өнөөгийн байдал болон гадаадын зарим улсын туршлага: Харьцуулсан судалгаа зэрэг судалгааны бүтээлүүд тус тус нийтлэгдлээ.

LIKE US ON
FACEBOOK:

ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН



www.jtrii.mn

LINKED IN:

ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН, ХҮРЭЭЛЭН



АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД ШИНЭЭР ТОМИЛОГДСОН ШҮҮГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭН, ДАДЛАГАЖУУЛАХ СУРГАЛТ ЭХЛЭЛЭЭ



Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шинээр томилогдсон шүүгчийг мэргэшүүлэн, дадлагажуулах зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд сургалт зохион байгуулав.

Энэ удаагийн сургалтад Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд 2023 оны 07 дугаар сараас хойш томилогдсон нийт 32 шүүгч хамрагдаж байгаа бөгөөд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу Хүрээлэнгийн 16 сургагч багш сургалтыг удирдан явууллаа.

“МЕНТОРШИП-2024” ХӨТӨЛБӨРИЙН ЯВЦЫГ ДҮГНЭН, ХЭЛЭЛЦЛЭЭ

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн шинээр томилогдсон, залуу шүүгчийг чадавхжуулах “МЕНТОРШИП-2024” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд 3 сарын хугацаа өнгөрч байна.

Хөтөлбөрийн явц дунд Ментор, Менти шүүгчдийг биечлэн уулзах боломжоор хангахын зэрэгцээ хөтөлбөрийн явцыг үнэлэх зорилготой явцын уулзалтыг зохион байгууллаа.

Уулзалтаар Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Шүүхийн сургалтын төвийн дарга Г.Халиунаа нар хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үр дүн, явц, тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар оролцогчдын санал, сэтгэгдлийг сонсож, зохион байгуулагчийн зүгээс цаашид анхаарах асуудлын талаар харилцан яриа өрнүүллээ.



“ҮНДСЭН ХУУЛИЙН ХЭРЭГЛЭЭНД АНХААРАХ АСУУДАЛ” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн 2024 оны шүүгчийн сургалтын тандан судалгааны үр дүнг үндэслэн бүх шатны шүүхийн шүүгчдэд зориулан “Үндсэн хуулийн хэрэглээнд анхаарах асуудал” сэдэвт сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгууллаа.

Тус сургалтыг Монгол Улсын гавьяат хуульч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Сарантуяа “Үндсэн хуулийн Арван дөрөв болон Арван зургаадугаар зүйлийн заалтууд зөрчигдсөн эсэхэд дүн шинжилгээ хийх задаргаа мөн хууль Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянах онцлог болон Үндсэн хуулийн бусад зүйл зөрчигдсөн эсэхэд дүн шинжилгээ хийх онцлог” зэрэг дэд сэдвийн хүрээнд удирдан явуулав.



АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД ШИНЭЭР ТОМИЛОГДСОН ШҮҮГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭН, ДАДЛАГАЖУУЛАХ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ



Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт заасны дагуу Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шинээр томилогдсон шүүгчийг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд мэргэшүүлэн, дадлагажуулах сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд зохион байгууллаа.

Сургалтад 2023 оны 07 дугаар сараас хойш Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсон шүүгчид хамрагдав.

“ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ” СЭДЭВТ СУРГАЛТ БОЛЛОО

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн жил бүрийн 4 дүгээр сарын 26-ны өдөр тохиодог Дэлхийн оюуны өмчийн өдрийг угтан “Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт” сэдэвт сургалтыг Монгол Улсын оюуны өмчийн газар, АНУ-ын Патент, барааны тэмдгийн газар болон Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулав.

Сургалтыг “Оюуны өмчийн хэргүүдэд хохирол, алдагдлын хэмжээг тооцох нь”, “Оюуны өмч болон хиймэл оюун ухаан”, “Худалдааны нууцын хулгай”,



“Оюуны өмчийн хэргүүдэд хөрөнгө хураах, битүүмжлэх нь” сэдвийн хүрээнд АНУ-аас хүрэлцэн ирсэн шүүгч, мэргэжилтнүүд удирдан явууллаа.

ЭРҮҮ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ БОЛОН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Монгол банкттай хамтран “Хилийн чанадаас санхүүгийн эсвэл цахим нотлох баримтыг олж авахтай холбоотой тулгамдаж буй сорилт бэрхшээлүүд, шийдлүүд ба шүүх хуралдааны явцад олж авсан нотлох баримтыг зохистой ашиглах нь” сэдэвт сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Хоёр өдөр үргэлжилсэн сургалтыг АНУ-ын Виржиниа мужийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, Авлигын эсрэг гэмт хэргийн бие даасан зөвлөх А.Ж."Жек" де Клуйвер удирдан явуулсан юм.

